| | |
|---|---|
| Төслийн тайлант хугацаа | 2010 он |
| **Төслийн нэр, код** | **“Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх замаар хүүхдийг хүчирхийлэл, дарамт, мөлжлөгөөс хамгаалах” төсөл YS403** |
| Хандивлагч улс, олон улсын байгууллагын нэр | НҮБ-ын Хүүхдийн сан |
| Төслийн хэрэгжих хугацаа (эхлэх, дуусах огноо) | 2007-2011 он |
| Төслийн хэрэгжих салбар | Хүүхэд, гэр бүл |
| Төслийн хамрах хүрээ<br>/төсөлд хамрагдах байгууллага, хот, аймаг, орон нутгийн нэгж/ | Үндэсний хэмжээнд |
| Төслийн хүрээнд хийгдэх ажлууд, тэдгээрийг гүйцэтгэх төлөвлөгөө /он тус бүрээр/, гол зорилтот арга хэмжээ, шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байдал | Төслийг хэрэгжүүлснээр<br>1. Хүүхэд хамгааллын үйлчилгээний тодорхой хэм хэмжээ, эрх зүйн орчинг бүрдүүлэн хэрэгжүүлэх замаар хүүхдийн эрхийн тухай конвенцид заасны дагуу хүүхдийн эрхийг хангах<br>2. Хүүхдийн төлөөх бодлого, эрх зүйн шинэчлэлийг хийх зорилгоор эрх бүхий байгууллагууд болон бусад түншүүдийн оролцоотойгоор Засгийн газрын түвшинд дэмжлэг бүхий орчинг бий болгох<br>3. Хүүхэд хамгааллын талаарх бодлого, эрх зүйн орчинг сайжруулах зорилгоор тоон мэдээ, баримт цуглуулах үйл ажиллагааг сайжруулах, засгийн газрын тэргүүлэх оролцоотойгоор хүүхдийн нөхцөл байдалд хяналт үнэлгээ, хийж тайлагнах<br>4. Сонгосон нутаг дэвсгэрт хүүхдэд ээлтэй хамт олон, хамгаалалт бүхий орчин бий болж, хүүхдэд чанартай суурь үйлчилгээг хүргэх зохицуулалт, орон нутгийн оролцоо, манлайллыг хангах<br>Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 жилээр холбогдох талууд төрийн болон төрийн бус олон улсын байгууллагын төлөөлөл хамтран боловсруулж, 2010-2011 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталсан. |
| Төслийн хүрээнд тайлант хугацаанд /2010 оны байдлаар/ хийгдсэн ажлууд | - Хүүхэд хамгааллын чиглэлээр үзүүлж буй үйлчилгээ болон байгууллагуудын зураглал гаргах, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах талаар санал зөвлөмж боловсруулах зорилгоор асуулгын хуудас, маягт, зааврыг боловсруулан, хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж буй байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг цуглуулсан. Ажлын тайлан 2011 оны 2 сард гарна.<br>- Нийгмийн ажилтны ажлын байрны батлагдсан тодорхойлолтын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлсэн. Энэ хүрээнд нийгмийн ажлын өнөөгийн нөхцөл байдалд судалгаа хийсэн.<br>- Хүүхэд хамгаалал ба хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар нийгмийн ажилтны чадавхи бэхжүүлэх 3 өдрийн сургалтыг 9 аймагт зохион байгуулсан, Ээ ажил 2008 оноос эхэлсэн бөгөөд 2008-2010 онд улсын хэмжээнд 9 дүүрэг, 21 аймагт амжилттай зохион байгуулж, 1400-аад нийгмийн ажилтныг хамруулсан байна. |

| | |
|---|---|
| | - Хүүхдийн асрамж халамжийн хувилбарт үйлчилгээний сайн туршлагыг судлан, тэдгээрийн эмхэтгэсэн өгүүлэл боловсруулсан.<br>- Гэр бүлд түшиглэсэн халамжийн хувилбарт үйлчилгээний стандартын төслийг боловсруулсан.<br>- Хүүхэд, гэр бүлийн хөгжилд зориулсан цогц мэдээлэл бүхий вэб сайт байгуулах ажлыг эхлүүлэн вебийн бүтэц, агуулгыг тодорхойлж, вебэд тавигдах зарим мэдээллийг боловсруулсан. Веб сайтыг 2011 оны 4 сарын 1 гэхэд олон нийтийн хүртээл болгох зорилт тавьж байна.<br>- Хүн худалдах, хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих зохицуулах зөвлөлийн ээлжит хурал уулзалтыг зохион байгуулсан. |
| Төслийн нийт төсөв /мян.доллараар/ | 109492 USD |
| Төслийн 2010 оны төсөв | 56,818.599 төг |
| Төслийн хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээл, цаашид авах арга хэмжээ | o Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан тухайлбал Хүүхэд хамгааллын үндэсний стратеги боловсруулах, хүүхдийн хөгжил, хамгааллын асуудлаарх бүтэц тогтолцоог тодорхойлох, боловсронгуй болгох лобби нөлөөллийн ажил хийх /Хүүхдийн хөгжил хамгааллын УИХ-ын бүлэгтэй ажиллах/ үйл ажиллагааг Хүүхдийн төлөө газар зохицуулалт хийн ажиллаж байна. Дээрх ажлын гүйцэтгэлийг НҮБ-ын хүүхдийн сантай шууд гэрээлэн санхүүжилтээ авах замаар хэрэгжүүлж байна. Үйл ажиллагааны гүйцэтгэлийн талаарх мэдээллийг тус яаманд урьчилан ирүүлэх, гүйцэтгэлийн талаарх үйл ажиллагааны тайланг ирүүлж байхад анхаарахыг НҮБ-ын хүүхдийн сан бусад талуудад зөвлөсөн.<br>o Үйл ажиллагааны хүрээнд Ажлын хэсгийн гишүүн байгууллагуудын оролцоотойгоор хамтран ажилласан. Цаашид ч энэ хандлагыг улам бэхжүүлж багаар үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлнэ. |
| 2011 онд төслийн хүрээнд хийгдэхээр төлөвлөсөн томоохон ажлууд /огноо/ | • Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрүүдэд хүүхэд хамгааллын чиглэлээр дүн шинжилгээ хийх, зураглал гаргах<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхцөл байдлын талаарх судалгаа явуулах<br>• Хүүхэд, гэр бүлийн хөгжилд зориулсан цогц мэдээлэл бүхий вэб сайтыг байгуулан ажиллуулах<br>• Гэр бүлд түшиглэсэн халамжийн хувилбарт үйлчилгээний стандартыг асрамж халамжийн 1-2 төвд турших, стандартыг хэрэгжүүлэх талаар арга зүйн сургалтыг холбогдох ажилтанд зохион байгуулах гэх мэт. |

| | |
|---|---|
| Төслийн 2011 оны төсөв | |
| Төслийн менежерийн нэр, хаяг, утас, электрон хаяг | Төслийн дарга НХХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Т.Энхтуяа<br>Утас: 261844 enkhtuya@mswl.gov.mn<br>Төслийн зохицуулагч: НХХЯ-ны БХЗГ-ын мэргэжилтэн Д.Энхтуул<br>Утас 262686 denkhtuul@mswl.gov.mn |
| Төслийн хэрэгжилтэнд хяналт тавин ажилладаг төрийн байгууллагын холбогдох газар, хэлтэс, албан тушаалтны нэр, утас, электрон хаяг | НХХЯ-ны ТНБД У.Бямбасүрэн, Утас: 263436 byambasuren@mswl.gov.mn<br>НХХЯ-ны ТНБД-ын 2009 оны 11 сарын 25-ны 192 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг |